

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ... дугаар
сарын ... -ны өдөр

Улаанбаатар
хот

ТӨР-ИРГЭНИЙ ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ТУХАЙ

/Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн
шинэчилсэн найруулга/

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1 дүгээр зүйл.Хуулийн зорилго

1.1.Төр-Иргэний хяналт шалгалтын тухай хуулийн зорилго нь хүн, хуулийн этгээдийн ашгийн болон ашгийн бус үйл ажиллагааны улмаас хүний эрүүл, аюулгүй орчинд амьдрах, хөдөлмөрлөх, сурч, боловсрох эрх зөрчигдсөн эсэх, эсхүл зөрчигдөх эрсдэл үүсэж байгаа эсэхэд төр, төр-иргэний хяналт тавьж, нийтийн эрх, хууль ёсны ашиг сонирхолыг хамгаалахад оршино.

2 дугаар зүйл.Хяналт шалгалтын хууль тогтоомж

2.1.Төр-Иргэний хяналт шалгалтын тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын Засгийн газрын тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Захиргааны ерөнхий хууль, Засгийн газар дахь хяналтын тухай хууль болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2.Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

3 дугаар зүйл.Хуулийн үйлчлэх хүрээ

3.1.Төрийн хяналт шалгалтын байгууллагын үйл ажиллагааг хуулиар тусгайлан зохицуулснаас бусад хяналт шалгалттай холбоотой нийтлэг харилцааг энэ хуулиар зохицуулна.

3.2.Хуулиар эрх олгогдсоны дагуу төрийн захиргааны болон бусад байгууллагаас тодорхой чиглэл, салбарын хүрээнд зохион байгуулах хяналт шалгалтын үйл ажиллагаа нь энэ хуульд нийцсэн байна.

4 дүгээр зүйл.Хуулийн нэр томъёоны тодорхойлолт

4.1. Энэ хуульд заасан дараах нэр томьёог доор дурдсан утгаар ойлгоно:

4.1.1. “мэргэжлийн хяналт шалгалт” /цаашид “хяналт шалгалт” гэх/ гэж хүн, хуулийн этгээдийн үйл ажиллагаа /үйлдэл, эс үйлдэхүй/, ажил, үйлдвэрлэл, технологи, үйлчилгээ болон бараа, бүтээгдэхүүн, барилга байгууламж, техник, тоног төхөөрөмж, объект /цаашид “үйл ажиллагаа” гэх/ нь иргэдийн иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах, хөдөлмөрлөх, сурч боловсрох эрх зөрчигдсөн, эсхүл зөрчигдөх эрсдэл үүссэн тохиолдолд эрсдэлийг үнэлж, дүгнэх, зөвлөн туслах, гарсан алдаа дутагдлыг арилгуулахад чиглэсэн цогц арга хэмжээг;

4.1.2. “мэргэжлийн шалгалт” /цаашид “шалгалт” гэх/ гэж энэ хуулийн 4.1.1-д заасан цогц арга хэмжээг хэрэгжүүлэхэд хүн, хуулийн этгээдийн үйл ажиллагаа нь хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний акт, стандарт, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээнд заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг тодорхойлох үйл явцыг;

4.1.3. “зөвлөн туслах” гэж хүн, хуулийн этгээдийн үйл ажиллагааг хяналтын хуудсаар үнэлэн зөвлөгөө өгөх, мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх замаар эрсдэлээс урьдчилан сэргийлэх, бууруулахад чиглэсэн үйл ажиллагааг;

4.1.4. “тандан судлах” гэж хүн, хуулийн этгээдийн үйл ажиллагаанд хүний амь нас, эрүүл мэнд, нийгмийн болон хүрээлэн буй орчны аюулгүй байдалд хор хөнөөл учруулж болзошгүй хүчин зүйл байгаа эсэх, түүний шалтгааныг тодорхойлж, хянах үйл явцыг;

4.1.5. “эрсдэлийг үнэлэх” гэж хүн, хуулийн этгээдийн үйл ажиллагааны явцад холбогдох хууль тогтоомж, дүрэм, журам, норм, стандарт зөрчигдсөнөөс хүний амь нас, эрүүл мэнд, нийгмийн болон хүрээлэн буй орчны аюулгүй байдалд учирч болзошгүй сөрөг үр дагаврын түвшин, магадлалыг тодорхойлох үйл ажиллагааг;

4.1.6. “шинжилгээт шалгалт” гэж хууль тогтоомж, техникийн зохицуулалтын хэрэгжилт, стандартын шаардлагыг хангах зорилгоор орчин, түүхий эд, бараа, бүтээгдэхүүнээс дээж авч Үндэсний лавлагаа лабораторийн шинжилгээний дүнд үндэслэн шалгалт хийх үйл явцыг;

4.1.7. “хяналтын хуудас” гэж хүн, хуулийн этгээд (цаашид “шалгуулагч этгээд” гэх)-ийн явуулж байгаа үйл ажиллагаа нь иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах, хөдөлмөрлөх, сурч боловсрох эрх зөрчигдөх эрсдэлийг үнэлж, тодорхойлох үнэлгээний хуудсыг;

4.1.8. “хяналт шалгалтын байгууллага” гэж хуулиар хяналт шалгалтыг хэрэгжүүлэхээр тогтоосон байгууллага, хуульд заасны дагуу эрх шилжүүлэн авсан хуулийн этгээдийг;

4.1.9."улсын байцаагч" гэж хуульд заасны дагуу хяналт шалгалт явуулах эрх бүхий албан тушаалтныг;

5 дугаар зүйл.Хяналт шалгалтын зарчим

5.1.Хяналт шалгалт хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална:

5.1.1.хууль дээдлэх, хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэх;

5.1.2.хүний амь нас, эрүүл мэнд, хөдөлмөрлөх, сурч боловсрох, нийгмийн болон хүрээлэн буй орчны аюулгүй байдал нь бусад аливаа ашиг сонирхол, зорилгоос илүүд байх;

5.1.3.хүн, хуулийн этгээдийн үйл ажиллагаа нь иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах, хөдөлмөрлөх, сурч боловсрох эрх хөндөх, зөрчих, эсхүл хөндөх, зөрчих эрсдэл үүссэн тохиолдолд төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг зохион байгуулах;

5.1.4.нээлттэй, ил тод байх;

5.1.5.эрх бүхий байгууллага, албан тушаалтны шийдвэр, үйл ажиллагаа нь хуульд нийцсэн, нөлөөллөөс ангид байх;

5.1.6.хяналт шалгалттай холбоотой зардлыг улсын төсвөөс санхүүжүүлэх, хуульд зааснаас бусад тохиолдолд хяналт шалгалтын үйл ажиллагаатай холбоотой аливаа төлбөрийг шалгуулагч этгээдээс шаардахгүй байх;

5.1.7.хяналт шалгалтыг давхардуулахгүй зохион байгуулах;

5.1.8.хяналт шалгалтын дүгнэлт, шинжилгээний дүнг хяналт шалгалтын харилцан хүлээн зөвшөөрөх;

5.1.9.хяналт шалгалтад мэдээллийн технологийн дэвшлийг ашиглаж, хяналт шалгалтын бүртгэлийг цахим хэлбэрээр нэгтгэн бүртгэх, удирдах.

ХОЁРДУГААР БҮЛЭГ ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ХЭЛБЭР, ТӨРӨЛ

6 дугаар зүйл.Хяналт шалгалтын хэлбэр

6.1.Хяналт шалгалтыг тандан судлах, зөвлөн туслах үйл ажиллагаа, шалгалт, хяналт шалгалт хийх хэлбэрээр зохион байгуулна.

6.2.Тандан судалгааг эрсдэлийн шинжилгээ, шинжилгээт шалгалтын хэлбэртэй байх бөгөөд хяналт шалгалтын байгууллагын даргын баталсан удирдамжийн дагуу хэрэгжүүлнэ.

7 дугаар зүйл.Эрсдэлийн шинжилгээ

7.1.Хүн, хуулийн этгээдийн үйл ажиллагаа нь хүний амь нас, эрүүл мэнд болон хүрээлэн буй орчны аюулгүй байдалд хор хөнөөл учруулж болзошгүй эрсдэлт хүчин зүйл байгаа эсэх, түүний шалтгааныг тандан судлах зорилгоор эрсдэлийн шинжилгээ хийнэ.

7.2.Эрсдэлийн шинжилгээг хийхдээ иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдол, хэрэглэгчийн үнэлгээний саналыг харгалзан хийнэ.

7.3.Хүн, хуулийн этгээдийн үйл ажиллагааны эрсдэлийн түвшинг их, дунд, бага гэж ангилна.

7.4.Эрсдэлийн шинжилгээний үнэлгээгээр их, дунд түвшний эрсдэлтэй бол төлөвлөгөөт хяналт шалгалт, бага түвшний эрсдэлтэй бол зөвлөн туслах үйл ажиллагааг хийж гүйцэтгэнэ.

7.5.Хүн, хуулийн этгээдийн үйл ажиллагаанд эрсдэлийн шинжилгээний үнэлгээг 4 жил тутам хийж гүйцэтгэнэ.

8 дугаар зүйл.Шинжилгээт шалгалт

8.1.Хүрээлэн буй орчин, түүхий эд, бараа, бүтээгдэхүүн нь стандарт, техникийн зохицуулалттай нийцэж буй эсэхийг тогтоох зорилгоор шинжилгээт шалгалтыг зохион байгуулж болно.

8.2.Энэ хуулийн 8.1-д заасан шинжилгээт шалгалтыг лабораторид шинжилгээ хийх аргаар зохион байгуулна.

8.3.Шинжилгээт шалгалтыг төлөвлөгөөнд заасны дагуу, эсхүл хүн, хуулийн этгээдээс ирүүлсэн мэдээллийг үндэслэн Үндэсний лавлагаа лабораторийн шинжлүүлэн зохион байгуулна.

8.4.Шинжилгээт шалгалтыг хүн, хуулийн этгээдийн шинжилгээт шалгалтыг заавал танилцуулах, эсхүл мэдээллэхгүйгээр хийж гүйцэтгэж болно.

8.5.Шинжилгээт шалгалтыг энэ хуулийн 8.4-т заасны дагуу хийж гүйцэтгэхдээ шинжилгээ хийх арга, салбар, чиглэлийг Засгийн газрын Хяналтын газрын дарга батална.

8.6.Шинжилгээт шалгалтын үр дүнг үндэслэн энэ хуулийн 10.3.6-д заасан төлөвлөгөөт бүс хяналт шалгалтыг хийж болно.

9 дүгээр зүйл.Зөвлөн туслах үйл ажиллагаа

9.1.Улсын байцаагч нь хүн, хуулийн этгээдийн үйл ажиллагаанд хууль тогтоомж, дүрэм, журам, стандартыг мөрдүүлэхэд мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгч, зөвлөн туслах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

9.2.Дараах тохиолдолд зөвлөн туслах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

- 9.2.1.хуулийн этгээдийн шинээр эхлүүлж байгаа үйл ажиллагаанд;
- 9.2.2.хүн, хуулийн этгээдийн хүсэлтийн дагуу;
- 9.2.3.эрсдэлийн шинжилгээгээр бага эрсдэлтэй гэж үнэлэгдсэн бол;
- 9.2.4.хяналт шалгалтын мөрөөр;
- 9.2.5.шинжилгээт шалгалтын мөрөөр.

9.3.Зөвлөн туслах үйл ажиллагааг хууль, гэрээний үндсэн дээр мэргэжлийн нэгдсэн холбоо, төрийн бус байгууллага, олон нийтийн хяналтын зөвлөлөөр гүйцэтгүүлж болно.

9.4.Энэ хуулийн 9.2.1, 9.2.2-т заасан зөвлөн туслах үйл ажиллагааг цахим хэлбэрээр үзүүлж болно.

10 дугаар зүйл.Хяналт шалгалтын төрөл

10.1.Хяналт шалгалт нь төлөвлөгөөт, төлөвлөгөөт бус, гүйцэтгэлийн гэсэн төрөлтэй байна.

10.2.Төлөвлөгөөт хяналт шалгалт нь тандан судалгааг үндэслэж, олон нийтийн хяналтын зөвлөлийн саналыг харгалзан баталсан төлөвлөгөөний дагуу гүйцэтгэнэ.

10.3.Төлөвлөгөөт бус шалгалтыг дараах үндэслэлээр гүйцэтгэнэ:

10.3.1.хүн, хуулийн этгээдийн хүсэлт, өргөдөл, гомдол, мэдээлэл;
10.3.2.олон нийтийн хяналтын зөвлөлийн мэдээлэл, зөвлөмжийн дагуу;
10.3.3.осол аваар, халдварт өвчин, хордлого зэрэг хүний амь нас, эрүүл мэнд, нийгэм, соёлын болон хүрээлэн буй орчинд хор хохирол учруулсан, эсхүл учруулж болзошгүй эрсдэл үүссэн тохиолдолд;

10.3.4.Засгийн газрын шийдвэр, Ерөнхий сайдын захирамж, тухайн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний үүрэг, чиглэл, шийдвэрийн дагуу;

10.3.5.нийтийг хамарсан үйл явдал, нийтээр тэмдэглэх баяр болон тэмдэглэлт үйл явдал, улирлын чанартай ажил, үйлчилгээ эхлэхээс өмнө;

- 10.3.6.шинжилгээт шалгалтын үр дүнд;
- 10.3.7.хууль тогтоомжид заасан бусад үндэслэл.

10.4.Гүйцэтгэлийн шалгалтыг улсын байцаагчийн хяналтын баримт бичгийн дагуу зөрчил, дутагдлыг арилгасан эсэхэд хийж гүйцэтгэнэ.

11 дүгээр зүйл.Төлөвлөгөөт хяналт шалгалт

11.1.Төлөвлөгөөт хяналт шалгалтыг удирдамжийн дагуу энэ хуулийн 19 дүгээр зүйлд заасны гүйцэтгэнэ.

11.2.Хуульд өөрөөр заагаагүй бол төлөвлөгөөт хяналт шалгалтын үргэлжлэх хугацаа ажлын 15 хоногоос илүүгүй байх бөгөөд үүнд шалгалтын дүгнэлт гаргах хугацаа хамаарахгүй.

11.3.Санхүү, нийгмийн хамгааллын чиглэлийн хяналт шалгалтын үргэлжлэх хугацаа 30 хоногоос илүүгүй байна.

11.4.Төлөвлөгөөт хяналт шалгалтын үйл ажиллагаанд шалгуулагч хүн, хуулийн этгээдийг төлөөлөх эрх бүхий албан тушаалтныг байлцуулна.

11.5.Энэ хуулийн 11.4-т заасан тухайн төлөөлөх эрх бүхий этгээд байлцаагүй нь хяналт шалгалтыг хойшлуулах үндэслэл болохгүй.

12 дугаар зүйл.Төлөвлөгөөт бус шалгалт

12.1.Энэ хуулийн 10.3.3-т зааснаас бусад тохиолдолд удирдамжтайгаар шалгалтыг хийж гүйцэтгэж болно.

12.2.Хүн, хуулийн этгээдээс ирүүлсэн өргөдөл, гомдол, хүсэлтэд дурдсан агуулгын хүрээнд төлөвлөгөөт бус шалгалтыг хийж гүйцэтгэнэ.

12.3.Энэ зүйлийн 12.2-т заасан гомдол, өргөдөл, хүсэлтийг хүлээн авснаас хойш 3 хоногийн дотор судлан үзэж, шалгалтыг эхлүүлэх, эсхүл зөрчлийн шинжтэй бол Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд заасны дагуу шийдвэрлэнэ.

12.4.Хуульд өөрөөр заагаагүй бол тухайн үйл ажиллагаанд хийх төлөвлөгөөт бус шалгалтын үргэлжлэх хугацаа ажлын 10 хоногоос илүүгүй байх бөгөөд үүнд шалгалтын дүн гаргах хугацаа хамаарахгүй.

12.5.Энэ хуулийн 10.3-т зааснаас бусад үндэслэлээр төлөвлөгөөт бус шалгалт явуулахыг хориглоно.

13 дугаар зүйл.Гүйцэтгэлийн шалгалт

13.1.Гүйцэтгэлийн шалгалтыг төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус хяналт шалгалтын явцад илэрсэн алдаа, дутагдлыг арилгуулах талаар хяналт шалгалтын байгууллагаас өгсөн улсын байцаагчийн хяналтын баримт бичгийн биелэлтийг хянах зорилгоор явуулна.

13.2.Улсын байцаагчийн хяналтын баримт бичгийг биелүүлээгүй бол газар дээр нь гүйцэтгэлийн шалгалт хийж болно.

ГУРАВДУГААР БҮЛЭГ ХЯНАЛТ ШАЛГАЛТ ЯВУУЛАХ ЖУРАМ

14 дүгээр зүйл.Хяналт шалгалтын хүрээ

14.1.Дараах чиглэлийн хяналт шалгалтыг Засгийн газрын Хяналтын Ерөнхий газар хийж гүйцэтгэнэ:

14.1.1.эрүүл мэнд, эм, био бэлдмэлийн чанар, аюулгүй байдлын хяналт;

14.1.2.хүнс, мал, амьтан, ургамал хорио цээрийн хяналт;

14.1.3.хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хяналт;

14.1.4.уул уурхай, байгаль орчны хяналт;

14.1.5.барилга, эрчим хүчний хяналт;

14.1.6.цөмийн болон цацрагийн хяналт.

14.2.Энэ хуулийн 14.1-д зааснаас бусад чиглэлийн хяналт шалгалтыг хуульд өөрөөр заагаагүй бол энэ хуульд заасан нийтлэг журмын дагуу хийж гүйцэтгэнэ.

14.3.Дараах чиглэлийн хяналт шалгалтыг мэргэжлийн нэгдсэн холбоо, төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлж болно:

14.3.1.боловсролын хяналт;

14.3.2.автозам, авто тээврийн хяналт;

14.3.3.соёл, соёлын өв, аялал жуулчлалын хяналт;

14.3.4.мал үржүүлэг, технологийн хяналт;

14.3.5.эрсдэл багатай гэж үнэлэгдсэн бусад чиглэлийн хяналт.

15 дугаар зүйл.Хяналт шалгалтын арга

15.1.Хяналт шалгалтыг дараах нийтлэг аргаар явуулна:

15.1.1.үзлэг хийж, хяналтын хуудсаар эрсдэлийг үнэлэх;

15.1.2.тайлбар, мэдээлэл авах;

15.1.3.дээж авч шинжилгээнд хамруулах;

15.1.4.туршилт, хэмжилт, магадлал хийх;

15.1.5.мэдээлэл, баримт бичиг гаргуулан авах;

15.1.6.дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэг, гэрэл зураг авах;

15.1.7.тэмдэглэл үйлдэн баримтжуулах;

15.1.8.хуульд заасан бусад арга.

15.2.Хүн, хуулийн этгээдийн үйл ажиллагааны онцлог, чиглэлээс хамаарч хяналт шалгалтын аргыг холбогдох хуулиар тогтоож болно.

16 дугаар зүйл.Хяналт шалгалтад хориглох зүйл

16.1.Хүн, хуулийн этгээдийн эрхэлж байгаа үйл ажиллагаа иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах, хөдөлмөрлөх, сурч боловсрох эрхийг зөрчсөн, эсхүл зөрчигдөх эрсдэлтэй нөхцөл байдал үүссэн тохиолдлоос бусад үндэслэлээр шалгалт, хяналт шалгалтыг зохион байгуулахыг хориглоно.

16.2.Хяналт шалгалтыг явуулахад дараах зүйлийг хориглоно:

16.2.1.хуульд заасан үндэслэл, журмыг зөрчиж хяналт шалгалт хийх;

16.2.2.хяналт шалгалтыг урьдчилсан дүгнэлт гаргаж, түүнийгээ батлах замаар хэрэгжүүлэх;

16.2.3.хүний эрх, эрх чөлөө, нэр төр, алдар хүнд болон хуулийн этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхол, ажил хэргийн нэр хүндэд хохирол учруулах;

16.2.4.албан тушаалын давуу байдлаа ашиглан шалгуулагч этгээдэд аливаа дарамт шахалт үзүүлэх, хөнгөлөлт, үйлчилгээ, шан харамж авах;

16.2.5.улсын байцаагчийн эрхгүй этгээд хэрэгжүүлэх;

16.2.6.хяналтын хуудасны үнэлгээтэй нийцээгүй дүгнэлт гаргах;

16.2.7.хуульд зааснаас бусад тохиолдолд шалгуулагч этгээдээс төлбөр, хураамж, хяналт шалгалтын хүрээнээс давсан баримт бичиг шаардах;

16.2.8.хяналт шалгалттай холбоотой дүгнэлт, шийдвэр эцэслэн гараагүй байхад хүний нэр төр, алдар хүнд, хуулийн этгээдийн ажил хэргийн нэр хүндэд харш аливаа мэдээ, мэдээллийг олон нийтэд тараах;

16.2.9.хуульд заасан бусад.

17 дугаар зүйл.Хяналт шалгалтын төлөвлөгөө батлах, тайлагнах

17.1.Хяналт шалгалтын төлөвлөгөөг эрсдэлийн шинжилгээ болон хяналт шалгалтын байгууллагаас ирүүлсэн саналд үндэслэн Засгийн газрын Хяналтын ерөнхий газар нэгтгэн боловсруулна.

17.2.Төлөвлөгөөнд зорилго, чиглэл, шалгалтад хамруулах хүрээ, хуулийн этгээдийн нэрийг тусгах бөгөөд хэрэгжилтийг тухайн хяналт шалгалтын байгууллага хариуцна.

17.3.Засгийн газрын Хяналтын ерөнхий газрын дарга төлөвлөгөөг жил бүрийн 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор баталж, мэдээллийн санд байршуулж, олон нийтэд нээлттэй мэдээлнэ.

17.4.Засгийн газрын Хяналтын ерөнхий газар төлөвлөгөөний хэрэгжилтийн явцад хяналт тавьж, биелэлтийг хангуулах арга хэмжээ авна.

17.5.Хяналт шалгалтын байгууллага төлөвлөгөөний биелэлтийг хагас, бүтэн жилээр гаргаж, Засгийн газрын Хяналтын ерөнхий газарт жил бүрийн 6 дугаар сарын 15-ны өдөр, 12 дугаар сарын 05-ны өдөр тус тус цахим хэлбэрээр хүргүүлнэ.

17.6.Засгийн газрын Хяналтын ерөнхий газар нь хяналт шалгалтын дүнг жил бүр Засгийн газарт танилцуулна.

18 дугаар зүйл.Хамтарсан хяналт шалгалтыг зохион байгуулах

18.1.Хяналт шалгалтыг хэд хэдэн хяналт шалгалтын байгууллага хамтран зохион байгуулж болно.

18.2.Хүн, хуулийн этгээдэд хэд хэдэн хяналтын чиглэлээр хамтран хяналт шалгалт хийх бол Засгийн газрын Хяналтын Ерөнхий газар зохион байгуулж, нэгдсэн удирдамж батална.

18.3.Энэ хуулийн 18.1-д заасан хяналт шалгалтын бүрэлдэхүүнд шинжээч, шинжилгээний байгууллага, олон нийтийн хяналтын зөвлөлийг оролцуулж болно.

18.4.Энэ хуулийн 18.3-т заасан шинжээч, шинжилгээний байгууллага, олон нийтийн хяналтын зөвлөл, иргэний нийгмийн байгууллагад ажлын хөлс, томилолт, замын зардал олгох ба уг зардлыг батлагдсан төсөвт багтаан хяналт шалгалтын байгууллага тогтооно.

19 дүгээр зүйл.Хяналт шалгалтын удирдамж батлах

19.1.Хяналт шалгалтын удирдамжид хүн, хуулийн этгээдийг шалгах болсон үндэслэл, шалтгааныг заавал тусгана.

19.2.Хуульд өөрөөр заагаагүй бол хяналт шалгалтын удирдамжийг дараах эрх бүхий албан тушаалтан батална:

19.2.1.төлөвлөгөөт хяналт шалгалтын удирдамжийг Засгийн газрын Хяналтын ерөнхий газрын нэгжийн дарга, эсхүл хяналт шалгалтын байгууллагын дарга;

19.2.2.төлөвлөгөөт бус шалгалтын удирдамжийг Засгийн газрын Хяналтын ерөнхий газрын дарга, эсхүл хяналт шалгалтын байгууллагын дарга;

19.2.3.гүйцэтгэлийн шалгалтын удирдамжийг Засгийн газрын Хяналтын ерөнхий газрын нэгжийн дарга, эсхүл хяналт шалгалтын байгууллагын дарга.

19.3.Хяналтын хуудсыг тухай бүр удирдамжийн хавсралтаар батлуулна.

19.4.Шаардлагатай тохиолдолд удирдамж баталсан албан тушаалтан тухайн хяналт шалгалтын үргэлжлэх хугацаа, бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулж болно. Хяналт шалгалтыг удирдамжид заасан хугацаагаар сунгуулж болно.

20 дугаар зүйл.Хяналт шалгалтын үйл ажиллагааны үе шат

20.1.Хуульд өөрөөр заагаагүй бол хяналт шалгалтыг дараах үе шаттайгаар зохион байгуулна:

- 20.1.1.хяналт шалгалтад бэлтгэх;
- 20.1.2.хяналт шалгалтыг эхлэх;
- 20.1.3.хяналт шалгалтыг гүйцэтгэх;
- 20.1.4.хяналт шалгалтыг үнэлж, дүгнэх.

21 дүгээр зүйл.Хяналт шалгалтад бэлтгэх

21.1.Улсын байцаагч хяналт шалгалтад дараах бэлтгэл ажлыг урьдчилан хангана:

21.1.1.хяналт шалгалтын ажлын хэсгийн бүрэлдэхүүн, ахлагчийг томилж, хяналт шалгалтын хамрах хүрээ, хугацааг тодорхойлох;

21.1.2.хяналт шалгалтын удирдамжийг батлуулж, хяналт шалгалтын бүртгэл, мэдээллийн санд оруулж, дугаар авах;

21.1.3.хяналт шалгалтын түүхийг судалж, шалгалтад шаардагдах баримт бичгийг бэлдсэн байх;

21.1.4.хяналт шалгалтад хэрэглэгдэх багаж, техник хэрэгслийг бэлэн болгож, найдвартай ажиллагааг нь хангасан байх.

22 дугаар зүйл.Хяналт шалгалтыг эхлэх

22.1.Хяналт шалгалтын ажлын хэсгийн ахлагч шалгуулагч этгээдэд тухайн хяналт шалгалтын зорилго, бүрэлдэхүүнийг танилцуулж эхлүүлнэ.

22.2.Ажлын хэсгийн ахлагч нь хяналт шалгалтын удирдамжид заасан чиглэлийн дагуу хийх ажил, хугацааг улсын байцаагч тус бүрээр тогтоож, хяналт

шалгалтыг шалгуулагч этгээдийн үйл ажиллагаанд аль болох саад учруулахгүйгээр зохион байгуулж ажиллана.

23 дугаар зүйл.Хяналт шалгалтыг гүйцэтгэх

23.1.Хяналт шалгалтын явцад улсын байцаагч шалгалтын тэмдэглэл, хяналтын хуудсыг шалгуулагч этгээдэд танилцах боломжоор хангана.

23.2.Хүн, хуулийн этгээдийн өргөдөл, хүсэлт, гомдол, мэдээлэлд дурдсан асуудлаар төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг хийхдээ гомдол гаргагч болон эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа тал, шалгуулагч этгээдийн санал, хүсэлт, тайлбарыг авна.

23.3.Улсын байцаагч хяналт шалгалтыг хяналтын хуудсаар үнэлэн, шалгуулагч этгээдийн эрсдэлийн түвшинг тогтооно.

23.4.Шаардлагатай бол хяналт шалгалтын явцад хэмжилт, туршилт, магадлалыг хийж, дээж авч шинжилгээнд хамруулна.

23.5.Хяналт шалгалтын явцад зөрчил илэрсэн бол эрсдэлийн үнэлгээнд үндэслэн шалтгаан, нөхцөлийг арилгах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

23.6.Хяналт шалгалтын явцыг дууны, дүрсний, дуу-дүрсний төхөөрөмж ашиглах зэрэг боломжит арга хэрэгслээр баримтжуулж болно.

23.7.Улсын байцаагч шалгуулагч этгээдээс авсан баримт бичиг, шинжилгээний дээж, баримтын бүрэн бүтэн, аюулгүй байдлыг хариуцна.

23.8.Улсын байцаагч хяналт шалгалтыг хэрэгжүүлэх явцдаа шалгуулагч этгээдийн эрсдэлийн үнэлгээний дүнг танилцуулж, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, бууруулах талаар мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх замаар зөвлөн тусална.

23.9.Шалгуулагч этгээдийн зүгээс хяналт шалгалтын ажилд саад учруулах, шаардлагатай баримт материалыг гаргаж өгөхгүй байх, хяналт шалгалтын дүнг хүлээн зөвшөөрөөгүй нь хяналт шалгалтыг зогсоох, хойшлуулах үндэслэл болохгүй.

23.10.Улсын байцаагч хяналт шалгалт хийхдээ шаардлагатай баримт бичиг, холбогдох судалгаа, мэдээллийг шалгуулагч этгээдийн эрх бүхий албан тушаалтнаар баталгаажуулан хүлээн авч, шалгалт дууссаны дараа хүлээлгэж өгнө.

23.11.Улсын байцаагч нь хяналт шалгалт хийхдээ шаардлагатай байр танхим, техник хэрэгслийг шалгуулагч этгээдээс гаргуулж болно.

24 дүгээр зүйл.Хяналт шалгалтын дүгнэлт

24.1.Улсын байцаагч нь хяналт шалгалтын явцад цугларсан баримтад үндэслэн шалгуулагч этгээдийн үйл ажиллагаа нь хяналтын хуудасны эрсдэлийн үнэлгээ, хууль тогтоомж, журам, дүрэм, стандарт, тохирлын үнэлгээнд заасан шаардлагыг хангаж байгаа эсэхэд дүгнэж, шаардлагатай тохиолдолд Улсын байцаагчийн дүгнэлт гаргана.

24.2.Хяналт шалгалтын дүгнэлт, авч буй арга хэмжээний талаар шалгуулагч этгээдэд танилцуулна.

24.3.Улсын байцаагч шаардлагатай гэж үзвэл хяналт шалгалтын дүгнэлтийг үндэслэн дараах хяналтын баримт бичиг гаргах арга хэмжээ авна:

24.3.1.“эрсдэл бага” гэж дүгнэсэн бол зөвлөмж хүргүүлэх;

24.3.2.“эрсдэл дунд” гэж дүгнэсэн бол албан шаардлага хүргүүлэх;

24.3.3.“эрсдэл их” гэж дүгнэсэн бол Зөрчлийн тухай хуульд заасан арга хэмжээ авах.

24.4.Хяналт шалгалтын дүгнэлт гарсаны дараа хувийн хэрэг нээж, энэ хуульд заасан хяналт шалгалтын бүртгэл, мэдээллийн санд оруулна.

25 дугаар зүйл.Гүйцэтгэлийн шалгалт

25.1.Улсын байцаагч албан шаардлага, актын биелэлтийн тайланг хүлээн авч, гүйцэтгэлийн шалгалт хийх эсэх саналаа ажлын 5 хоногийн дотор улсын ахлах байцаагчид танилцуулж шийдвэрлүүлнэ.

25.2.Улсын байцаагч Зөрчлийн тухай хуульд заасан зөрчлийн шийтгэл ногдуулсан тохиолдолд гүйцэтгэлийн шалгалтыг заавал хийнэ.

25.3.Гүйцэтгэлийн шалгалтыг улсын байцаагчийн удирдамжийн хүрээнд хийнэ.

25.4.Гүйцэтгэлийн шалгалтаар албан шаардлага, актад заасан үүрэг даалгаврыг биелүүлээгүй бол Зөрчлийн тухай хуульд заасны дагуу арга хэмжээ авна.

26 дугаар зүйл.Хяналт шалгалтын явцад илрүүлсэн зөрчлийг шийдвэрлэх

26.1.Хяналт шалгалтын явцад Зөрчлийн тухай хуульд заасан зөрчлийг хяналтын хуудсаар эрсдэл бага гэж үнэлсэн бол уг зөрчилд хугацаатай албан шаардлага хүргүүлж болно.

26.2.Энэ хуулийн 26.1-д заасан албан шаардлагад заасан хугацаанд зөрчлийг арилгах арга хэмжээ аваагүй бол Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн дагуу шийдвэрлэнэ.

26.3.Хяналт шалгалт хийх явцад олж мэдсэн гэмт хэргийн шинжтэй үйлдэл, үйл ажиллагаа, мэдээллийг хяналтын улсын байцаагч зохих журмын дагуу хуулийн байгууллагад мэдээлнэ.

Тайлбар:Энэ зүйлийн 26.1-д заасан зохицуулалтыг Зөрчлийн тухай хуулийн шинэчилсэн найруулга батлагдах хүртэл дагаж мөрдөнө.

27 дугаар зүйл.Улсын байцаагчийн хяналтын баримт бичиг

27.1.Улсын байцаагч нь хяналт шалгалтын чиг үүргээ хэрэгжүүлэхдээ зөвлөмж, дүгнэлт, албан шаардлага, актыг цаасан, эсхүл цахим хэлбэрээр гаргана.

27.2.Улсын байцаагчийн хяналтын баримт бичгийн бусад төрлийг хуулиар тогтоож болно.

27.3.Улсын байцаагчийн хяналтын баримт бичиг хууль, эрсдэлийн үнэлгээнд нийцсэн байна.

27.4.Улсын байцаагчийн хяналтын хуудасны загварыг Засгийн газрын Хяналтын ерөнхий газрын дарга бөгөөд улсын ерөнхий байцаагч батална.

27.5.Зөвлөмжийг шалгуулагч этгээдийн үйл ажиллагааны эрсдэлийг үнэлэн хууль зүйн болон мэргэжлийн зөвлөгөө өгөх чиглэлээр гаргана.

27.6.Шаардлагатай тохиолдолд зөвлөмжийн биелэлтийг зөвлөмжид заасан хугацаанд ирүүлэхийг шаардаж болно. Зөвлөмжийн биелэлтийг тогтоосон хугацаанд хяналт шалгалтын байгууллагад ирүүлээгүй бол албан шаардлага хүргүүлж болно.

27.7.Дүгнэлтээр барилга, байгууламж, бараа бүтээгдэхүүн, ажил, үйлдвэрлэл, үйлчилгээний чанар аюулгүй байдал нь хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний акт, стандарт, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний шаардлагыг хангаж байгаа эсэхийг тодорхойлно.

27.8.Албан шаардлагыг хяналт шалгалтаар илэрсэн алдаа дутагдал, түүний шалтгаан нөхцөлийг арилгах талаар холбогдох хүн, хуулийн этгээд, албан тушаалтанд хугацаатай үүрэг даалгавар өгч, биелэлтийг хангуулах чиглэлээр гаргана.

27.9.Хяналтын баримт бичигт эрсдэлийн үнэлгээ, тогтоогдсон бодит нөхцөл байдал, алдаа дутагдал илэрсэн бол үндэслэл, шалтгааныг нарийвчлан тусгана.

27.10.Улсын байцаагчийн хяналтын баримт бичиг үндэслэлгүй гэж тогтоогдсон бол улсын байцаагч өөрөө, эсхүл түүний дээд шатны албан тушаалтан өөрчлөх, эсхүл хүчингүй болгож болно.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН АЖИЛЛАГАА

28 дугаар зүйл. Үзлэг хийх

28.1.Улсын байцаагч нь хүн, хуулийн этгээдийн объект, үйлдвэрлэл, үйлчилгээ, үйл ажиллагаа хууль, захиргааны хэм хэмжээний акт, стандарт, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээнд заасан шаардлагыг хангаж байгаа эсэхийг тогтоох зорилгоор үзлэг хийнэ.

28.2.Үзлэг хийхэд шалгуулагч, шаардлагатай тохиолдолд тухайн объектын хууль ёсны өмчлөгч, эзэмшигчийг байлцуулна.

28.3.Энэ хуулийн 28.2-т заасан этгээд байлцах боломжгүй бол хөндлөнгийн этгээдийг байлцуулах, эсхүл гэрэл зураг, дуу, дүрсний, дуу-дүрсний бичлэгээр бэхжүүлж болно.

28.4.Үзлэг хийх үед Зөрчлийн тухай хуульд заасан зөрчил илэрвэл Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд заасан арга хэмжээ авч, тэмдэглэлд тусгана.

28.5.Үзлэг хийх явцад хүний амь нас, эрүүл мэнд, нийгмийн болон хүрээлэн буй орчинд аюул, орчинд хөнөөл учруулж болзошгүй тэсэрч дэлбэрэх болон химийн хортой бодис, бусад эд зүйл байна гэж үзвэл холбогдох мэргэжилтнийг оролцуулж, хуульд заасан арга хэмжээг авч ажиллана.

28.6.Үзлэг хийх явцад шаардлагатай бол энэ хуулийн 32.1-д заасны дагуу дээж авч, шинжилгээний байгууллагад хүргүүлнэ.

29 дүгээр зүйл. Тайлбар авах

29.1.Улсын байцаагч хяналт шалгалттай холбоотой асуудлаар шалгуулагч этгээдээс тайлбар авч болно.

29.2.Тайлбарыг асуулт, хариултын хэлбэрээр авах бөгөөд шаардлагатай бол тайлбар өгч байгаа хүн тайлбараа бичгээр эсхүл цахим хэлбэрээр өгч болно.

29.3.Тайлбарыг тэмдэглэлээр баталгаажуулах бөгөөд тайлбар авсан он, сар, өдөр, эхэлсэн дууссан хугацаа, тайлбар авсан газрыг тодорхой тусгаж, тайлбар авсан улсын байцаагч болон шалгуулагч этгээд баталгаажуулна.

29.4.Шалгуулагч этгээд тайлбар өгөхөөс татгалзсан бол энэ тухай тэмдэглэлд тусгана.

30 дугаар зүйл.Бичиг баримт, мэдээлэл гаргуулан авах

30.1.Улсын байцаагч нь хяналт шалгалтад шаардлагатай баримт бичгийг шалгуулагч этгээдээр баталгаажуулан хүлээн авч, шалгалт дууссаны дараа албан журмаар хүлээлгэж өгнө. Шаардлагатай бол хуулбарлан авч болно.

30.2.Шалгуулагч этгээд улсын байцаагчийн албан даалгаварт заасан хугацаа, хэлбэрийн дагуу мэдээлэл, баримт бичгийг гарган өгнө.

30.3.Баримт бичиг, мэдээлэл эргэлзээтэй бол түүний бодит нөхцөл байдлыг тогтоох зорилгоор нэмэлт тайлбар, мэдээлэл гаргуулан авна.

31 дүгээр зүйл.Шинжилгээнд зориулж дээж авах, шинжилгээ хийлгэх

31.1.Шинжилгээ хийх зорилгоор эд зүйл, баримт бичиг, ургамал, мал амьтнаас хэв загвар, дээж авч болно.

31.2.Шинжилгээнд зориулж хэв загвар, дээж авах ажиллагаанд тусгай мэдлэг бүхий мэргэжилтнийг оролцуулж болно.

31.3.Орчин тойрондоо аюул учруулж болзошгүй мал, амьтан, тэсэрч дэлбэрэх, хорт бодис, бусад байдлаар аюул учруулж болзошгүй эд зүйлээс хэв загвар, дээж авахдаа аюулгүй байдлыг хангах арга хэмжээг урьдчилан авна.

31.4.Хяналт шалгалтын явцад дээж авах бол улсын байцаагч тэмдэглэл бичих бөгөөд түүнд дараах зүйлийг тусгана:

31.4.1.дээж авах тухай тэмдэглэл бичсэн он, сар, өдөр, газар;

31.4.2.шалгуулагч этгээдийн нэр, хаяг;

31.4.3.дээж авахад байлцсан шалгуулагч этгээдийн төлөөлөгчийн нэр, албан тушаал;

31.4.4.дээж авсан улсын байцаагчийн эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, албан тушаал;

31.4.5.дээж авах үндэслэл, шаардлага;

31.4.6.импортолсон улс болон үйлдвэрлэгчийн нэр;

31.4.7.дээж авсан хугацаа, бүтээгдэхүүний нэр, төрөл, савлалт, цувралын дугаар, үйлдвэрлэсэн болон хадгалалтын дуусах хугацаа, нийт импортолсон болон дээж авсан тоо хэмжээ, дээжийн үнэ.

31.5.Энэ хуулийн 31.4-т заасан тэмдэглэлийг шалгуулагч этгээд болон Үндэсний лавлагаа лабораторид хүргүүлнэ.

31.6.Улсын байцаагч холбогдох журмын дагуу дээж авч тухайн дээжийн бүрэн бүтэн байдал, ариун чанар, хадгалалтын горимыг хангана.

31.7.Шалгуулагч этгээд дээж авах явцад байлцаж санал, гомдол гаргах эрхтэй.

31.8.Дээж, загвар авснаар шалгуулагч этгээдийн үйлдвэрлэлийн горимын хэвийн үйл ажиллагаа алдагдах эд зүйл, хэрэгслийг шинжлүүлэхээр авсан тохиолдолд түүнийг шинжилсний дараа нэн даруй буцаан олгоно.

31.9.Хяналт шалгалтын байгууллага шинжилгээнд авах дээжийн үнийг төлөх бөгөөд тухайн бүтээгдэхүүний үнийг тодорхойлох аргачлалыг санхүүгийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн болон хяналт шалгалтын асуудал хариуцсан Засгийн газрын гишүүн хамтран батална.

31.10.Дараах тохиолдолд шинжилгээний төлбөрийг хүн, хуулийн этгээдээс гаргуулна:

31.10.1.хүн, хуулийн этгээдийн хүсэлтийн дагуу;

31.10.2.хяналт шалгалтын явцад шалгуулагчийн дээж нь хууль тогтоомж, стандартад заасан шаардлагыг хангаагүй, түүнчлэн давтан шинжилгээ хийсэн.

31.11.Ажил, үйлчилгээ гүйцэтгэхэд тавигдах стандартын шаардлагад нийцэж байгаа эсэхийг тогтоох зорилгоор хүнд шинжилгээ хийлгэж болно.

31.12.Дээж авах, тээвэрлэх, шинжилгээ хийх нарийвчилсан журмыг Засгийн газар батална.

31.13.Энэ хуулийн 31.10-т заасан шинжилгээний төлбөрийг тухайн лаборатори өөрийн орлогод тооцож, урвалж бодис болон шинжилгээний тоног төхөөрөмж авахад зарцуулна.

32 дугаар зүйл.Туршилт, хэмжилт, магадлал хийх

32.1.Үзлэг хийх явцад бодит нөхцөл байдлыг нарийвчлан тогтоох зорилгоор туршилт, хэмжилт, магадлал хийж болно.

32.2.Туршилт, хэмжилт, магадлал хийхэд хүний амь нас, эрүүл мэнд, нийгмийн болон хүрээлэн буй орчинд хохирол учруулах арга, технологи ашиглахыг хориглоно.

32.3.Туршилт, хэмжилт, магадлал хийх нийтлэг журмыг Засгийн газар батална.

33 дугаар зүйл.Шалгалтын тэмдэглэл

33.1.Хуульд өөрөөр заагаагүй бол шалгалтын тэмдэглэлд үйл ажиллагааны явц, дэс дараалал, илэрсэн нөхцөл байдал, авсан арга хэмжээ, үр дүн болон дараах нийтлэг зүйлийг тусгана:

33.1.1.хяналт шалгалтыг хийсэн улсын байцаагчийн нэр, албан тушаал;

33.1.2. хяналт шалгалтыг хийсэн газар, эхэлсэн, дууссан он, сар, өдөр, цаг, минут, хэрэгжүүлэх явцад хугацаа тасалдсан бол түүний шалтгаан, хугацаа;

33.1.3.шалгуулагч болон ажиллагаанд байлцсан хүний эцэг /эх/-ийн болон өөрийн нэр, оршин суугаа газрын хаяг, холбоо барих утасны дугаар;

33.1.4.шалгуулагчид эрх, үүргийг тайлбарласан тухай тэмдэглэл;

33.1.5.шалгуулагч, эсхүл энэ хуулийн 28.2-т заасан хөндлөнгийн этгээд санал, хүсэлт гаргасан эсэх, түүнийг хэрхэн шийдвэрлэсэн талаар.

33.2.Улсын байцаагч болон шалгуулагч, ажиллагаанд оролцогч нар тэмдэглэлийг баталгаажуулна. Шалгуулагч, оролцогч талууд баталгаажуулахаас татгалзсан, эсхүл баталгаажуулах боломжгүй бол шалтгааныг тэмдэглэлд тусгана.

33.3.Тэмдэглэлд нэмэлт оруулсан, засвар хийсэн бол тайлбар, мэдээллийг тусгаж, баталгаажуулна.

33.4.Хяналт шалгалтын явцад хийсэн дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэг, гэрэл зураг, гар зураглал, хэв загварыг тэмдэглэлд хавсаргана.

34 дүгээр зүйл.Хяналтын хуудас

34.1.Хяналт шалгалтаар шалгуулагч этгээдийн үйл ажиллагааны онцлог, хяналтын чиглэлээс хамаарч нэг ба хэд хэдэн хяналтын хуудсаар үнэлж, эрсдэлийн түвшинг тогтооно.

34.2.Хяналтын хуудасны нийтлэг загвар, хэрэглэх аргачлалыг Засгийн газрын Хяналтын ерөнхий газрын дарга батална.

ТАВДУГААР БҮЛЭГ ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН БАЙГУУЛЛАГЫН ТОГТОЛЦОО, ЧИГ ҮҮРЭГ

35 дугаар зүйл.Хяналт шалгалтын байгууллага

35.1.Хяналт шалгалтын байгууллагын тогтолцоо нь Засгийн газрын Хяналтын ерөнхий газар, Үндэсний лавлагаа лаборатори, аймаг, дүүргийн хяналтын газар, хэлтэс, хяналтын улсын байцаагчаас бүрдэнэ.

35.2.Хяналт шалгалтын байгууллага нь нэгдмэл тогтолцоо, төвлөрсөн удирдлагатай байна.

35.3.Хяналт шалгалтын байгууллагын үйл ажиллагааг улсын төсвөөс санхүүжүүлэх бөгөөд энэхүү төсөв нь уг байгууллага чиг үүргээ бүрэн хэрэгжүүлэх шаардлагыг хангасан байна.

35.4.Хяналт шалгалтын байгууллагын орон нутаг дахь газар, хэлтсийн улсын байцаагчийн үйл ажиллагаагаа хэвийн явуулах нөхцөлийг бүрдүүлэхэд нутгийн өөрөө удирдах байгууллага, Засаг дарга дэмжлэг үзүүлнэ.

35.5.Энэ хуулийн 35.1-д зааснаас бусад хуульд заасан хяналтын чиглэлийг Улсын байцаагчийн эрх олгосноор тухайн асуудлыг эрхэлсэн төрийн байгууллага хариуцна.

35.6.Хяналт шалгалтын байгууллага дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

35.6.1.хууль, дүрэм, журам, стандарт, техникийн зохицуулалтын хэрэгжилт, биелэлтэд хяналт шалгалт хийх;

35.6.2.хяналт шалгалт явуулахтай холбогдсон заавар, маягт, аргачлал, техникийн ерөнхий шаардлага, хяналтын хуудсыг хууль тогтоомж болон энэ хуулийн 3 дугаар бүлэгт заасан нийтлэг журамд нийцүүлэн батлах;

35.6.3.орон нутгийн хяналтын байгууллагыг мэргэжил, арга зүй, зохион байгуулалтын удирдлагаар хангах;

35.6.4.хяналтын улсын байцаагчийг бэлтгэх, давтан сургах ажлыг зохион байгуулах;

35.6.5.хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх.

35.7.Хуульд өөрөөр заагаагүй бол хяналт шалгалтын байгууллага улсын төсөвт орлого төвлөрүүлэх үүргийг хүлээхгүй.

35.8.Энэ хуулийн 35.1-д заасан Үндэсний лавлагаа лабораторийн дүрэм, ажиллах журам, үйлчилгээний хөлс, бүтэц, орон тоог Засгийн газрын Хяналтын ерөнхий газрын дарга батална.

36 дугаар зүйл.Хяналтын улсын байцаагч

36.1.Хяналт шалгалтын байгууллагад улсын ерөнхий байцаагч, улсын ахлах байцаагч, улсын байцаагч, аймаг, сум, дүүргийн байгууллагад улсын ахлах байцаагч, улсын байцаагч ажиллана.

36.2.Улсын байцаагч, улсын ахлах байцаагчийн эрхийг Улсын ерөнхий байцаагч, Улсын ерөнхий байцаагчийн эрхийг Засгийн газар олгоно.

36.3.Хуульд өөрөөр заагаагүй бол улсын байцаагчийн эрх олгох, түдгэлзүүлэх, сэргээх, цуцлах журмыг Засгийн газар батална.

36.4.Хяналтыг хэрэгжүүлэх орон нутгийн байгууллагын дарга нь улсын ахлах байцаагч байна.

36.5.Хяналтыг хэрэгжүүлэх орон нутгийн байгууллагын улсын байцаагчийг тухайн орон нутаг дахь улсын ахлах байцаагч томилж, чөлөөлнө.

36.6.Улсын байцаагчийг ажлын онцлог, нутаг дэвсгэрийн байршлаас шалтгаалан 3 жил тутамд сэлгэн ажиллуулж болно.

37 дугаар зүйл.Улсын байцаагчийн нийтлэг эрх, үүрэг

37.1.Улсын байцаагч нь Төрийн албаны тухай хуульд зааснаас гадна дараах нийтлэг эрх, үүргийг хэрэгжүүлнэ:

37.1.1.хууль тогтоомж, дүрэм, журам, стандарт, техникийн шаардлагын биелэлтэд хяналт тавих;

37.1.2.хяналт шалгалт хийх об'ектод саадгүй нэвтрэх;

37.1.3.хуулиар хориглосноос бусад хяналт шалгалтын ажилд шаардлагатай мэдээ, судалгаа, тайлбар, тодорхойлолт, баримт бичгийг холбогдох хүн, хуулийн этгээд, албан тушаалтнаас үнэ төлбөргүй гаргуулан авах;

37.1.4.хяналт шалгалтын явцад илэрсэн алдаа дутагдлыг таслан зогсоох, түүний шалтгаан нөхцөлийг арилгах, учирч болох хор хохирлыг гаргуулахгүй, нэмэгдүүлэхгүй байх зорилгоор хүн, хуулийн этгээд, албан тушаалтанд хугацаатай үүрэг даалгавар өгч биелэлтийг хангуулах;

37.1.5.улсын байцаагч хийсэн хяналт шалгалт дүгнэлт, хяналтын баримт бичгийн үндэслэлийн үнэн зөвийг бүрэн хариуцах;

37.1.6.Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль болон бусад холбогдох хууль, тогтоомжид заасны дагуу мэдээлэл задруулахгүй байх, нууцыг хадгалах;

37.1.7.хууль тогтоомжид заасан бусад эрх.

37.2.Улсын ерөнхий байцаагч, улсын ахлах байцаагч энэ хуулийн 37.1-д зааснаас гадна дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

37.2.1.төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус хяналт шалгалтын удирдамжийг батлах;

37.2.2.улсын байцаагчийн хяналт шалгалтын үйл ажиллагаа, хяналтын баримт бичигтэй холбогдуулан гаргасан гомдлыг хянан шийдвэрлэх;

37.2.3.холбогдох байгууллагатай тохиролцон мэргэжлийн хүмүүсийг хяналт шалгалтын ажилд татан оролцуулах, шаардлагатай асуудлыг магадлах зорилгоор лабораторийн, эсхүл магадлан шинжилгээг мэргэжлийн байгууллага, шинжээчээр гүйцэтгүүлэх.

37.3.Улсын байцаагч албаны үнэмлэх, хувийн дугаар бүхий таних тэмдэгтэй байна.

37.4.Улсын байцаагч хүн, хуулийн этгээдэд дүгнэлт, хяналтын баримт бичгийн үндэслэл, шалтгааныг мэдэгдэж, эрх, үүрэг болон гомдол гаргах журмыг тайлбарлаж өгөх үүрэгтэй.

37.5.Улсын байцаагчийн шаардлагыг биелүүлээгүй, биелүүлэхээс татгалзсан, эсхүл үйл ажиллагаанд нь саад учруулсан бол хуульд заасан арга хэмжээ авна.

38 дугаар зүйл.Улсын байцаагчийн бүрэн эрхээ хэрэгжүүлэх баталгаа

38.1.Улсын байцаагч Төрийн албаны тухай хууль болон бусад хууль тогтоомжид заасан нэмэгдэл, баталгаагаар хангагдана.

38.2.Улсын байцаагчийн хянан шалгах үүргээ гүйцэтгэхэд шаардагдах хөдөлмөр хамгааллын хувцас болон техник хэрэгслээр хангагдана.

38.3.Улсын байцаагчид нэмэгдэл олгох журмыг Засгийн газрын Хяналтын ерөнхий газрын дарга батална.

ЗУРГААДУГААР БҮЛЭГ ОЛОН НИЙТИЙН ХЯНАЛТ

39 дүгээр зүйл.Олон нийтийн хяналтын үйл ажиллагаа

39.1.Олон нийтийн болон хэрэглэгчийн үнэлгээний саналыг олон нийтийн хяналтын зөвлөлөөр дамжуулан хэрэгжүүлэх ба хяналт шалгалтын байгууллагын дэргэд хяналтын чиглэл тус бүрээр орон тооны бус олон нийтийн хяналтын зөвлөл /цаашид "Зөвлөл" гэх/ ажиллана.

39.2.Зөвлөл нь хүн, хуулийн этгээдийн явуулж байгаа үйл ажиллагаа нь хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний акт, стандарт, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээнд заасан шаардлагад нийцэж байгаа эсэхэд хөндлөнгийн хяналтыг хэрэгжүүлж хяналт шалгалтын байгууллагад мэдээлэл, зөвлөмж хүргүүлж ажиллана.

39.3.Зөвлөл нь үйл ажиллагаандаа хууль дээдлэх, бусдын нөлөөнд үл автах, ил тод, нээлттэй байх зарчмыг баримтална.

39.4.Зөвлөл нь хяналт шалгалтын байгууллагын хараат бус байдал, бие даасан үйл ажиллагаанд хүндэтгэлтэй хандана.

39.5.Зөвлөл нь хяналт тавих чиг үүргээ судалгаа, үнэлгээний арга хэлбэрээр явуулна.

39.6.Зөвлөл нь үйл ажиллагаандаа дараах зарчмыг баримтална:

39.6.1.улс төрийн болон бусад ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх;

39.6.2.шударга ёс, тэгш байдлыг эрхэмлэх;

39.6.3.судалгаа, үнэлгээ нь ил тод, үндэслэл бүхий байх;

39.6.4.судалгаа, үнэлгээг хараат бусаар явуулах;

39.6.5.судалгааны үр дүнд суурилсан, бодит байдалд нийцсэн байх;

39.6.6.олон нийтийн оролцоог хангах;

40 дүгээр зүйл.Зөвлөлийн чиг үүрэг

40.1.Зөвлөл нь хяналтын хүрээнд дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

40.1.1.хяналт шалгалтын хөндлөнгийн судалгаа, үнэлгээ хийх мэдээлэл, зөвлөмж боловсруулах;

40.1.2.хүн, хуулийн этгээдийн үйл ажиллагаанд хөндлөнгийн хяналтыг хэрэгжүүлж, хяналт шалгалтын байгууллагыг мэдээллээр хангах;

40.1.3.хяналт шалгалтын төлөвлөгөөний төсөлд санал өгөх;

40.1.4.хяналт шалгалтын байгууллагын шийдвэрээр хүн, хуулийн этгээдийн үйл ажиллагаанд тандан судалгаа хийхэд оролцох;

40.1.5.хүн, хуулийн этгээдийн хүсэлтийн дагуу зөвлөн туслах үйл ажиллагааг үзүүлэх, зөвлөмж хүргүүлэх;

40.1.6.хяналт шалгалтын байгууллагын даргын шийдвэрээр хяналт шалгалтын бүрэлдэхүүнд орж ажиллах;

40.1.7.хэрэглэгчийн үнэлгээний дүнг нэгтгэж, хяналт шалгалтын байгууллагад танилцуулж, мэдээлэл, зөвлөмж хүргүүлэх;

40.1.8.Хяналт шалгалтын үйл ажиллагаатай холбогдох хууль тогтоомж, дүрэм, журам, стандартыг хүн, хуулийн этгээдэд таниулж, сурталчлах.

41 дүгээр зүйл.Зөвлөлийн үйл ажиллагааны хэлбэр

41.1.Зөвлөлийн үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь Зөвлөлийн хуралдаан /цаашид "Хуралдаан" гэх/ байна.

41.2.Хуралдааныг улиралд 2-оос доошгүй удаа, зөвлөлийн хурлыг зарласнаар хийх ба гишүүдийн олонх оролцсоноор хуралдаан, хурлыг хүчинтэйд тооцно.

41.3.Зөвлөл нь ажиллах журам, хуралдааны дэг, зохион байгуулалтын асуудлаа өөрөө тогтоож ажиллана.

41.4.Хуралдаанаар хэлэлцэх асуудлыг Зөвлөлийн дарга, гишүүд санал болгож, хэлэлцэх эсэхийг хуралдаанаар шийдвэрлэнэ.

41.5.Зөвлөл ажлаа хяналт шалгалтын байгууллагын даргад жил бүр тайлагнана. Зөвлөл шаардлагатай гэж үзсэн асуудлыг тухай бүр чиглэл тус бүрийн хяналт шалгалтын байгууллагын даргад мэдээлж болно.

41.6.Зөвлөл үйл ажиллагааныхаа жилийн тайлан, мэдээллийг олон нийтэд мэдээлнэ.

42 дугаар зүйл.Зөвлөлийн бүтэц, зохион байгуулалт

42.1.Зөвлөл нь 7-9 гишүүний бүрэлдэхүүнтэй байх ба Зөвлөлийн гишүүнээр ял шийтгэлгүй, иргэний нийгмийг төлөөлөх иргэнийг хяналт шалгалтын байгууллагын дарга 2 жилийн хугацаагаар томилж, чөлөөлнө.

42.2.Зөвлөлийн гишүүнд төрийн албан хаагчийг нэр дэвшүүлэхгүй.

42.3.Зөвлөлийн гишүүнийг бүрэн эрхийн хугацаа дуусахаас өмнө дараах үндэслэлээр чөлөөлнө:

42.3.1. гэмт хэрэг үйлдэж гэм буруутайг нь шүүхээс тогтоосон;

42.3.2. төрийн улс төрийн болон төрийн жинхэнэ албанд сонгогдсон, эсхүл томилогдсон, бусад шалтгаанаар иргэний нийгмийн байгууллагыг төлөөлөх боломжгүй болсон;

42.3.3.чөлөөлүүлэх тухай хүсэлтээ өөрөө гаргасан, эсхүл эрүүл мэндийн болон хүндэтгэн үзэх бусад шалтгаанаар үүргээ гүйцэтгэх боломжгүй болсон;

42.3.4.Зөвлөлийн үйл ажиллагаанд хүндэтгэх шалтгаангүйгээр удаа дараа оролцоогүй.

43 дугаар зүйл.Зөвлөлийн бүрэн эрх, чиг үүргээ хэрэгжүүлэх баталгаа

43.1.Зөвлөл нь дараах бүрэн эрхийг хэрэгжүүлж ажиллана:

43.1.1.хууль, журамд заасан чиг үүргийг хэрэгжүүлэх нөхцөлийг хангаж ажиллах;

43.1.2.Зөвлөлийн ажлын өрөө, хуралдаан явуулах байр, шаардлагатай техник хэрэгслээр хангагдах;

43.1.3.Зөвлөлийн үйл ажиллагаанд шаардлагатай бусад туслалцаа, дэмжлэгээр хангагдах ба хууль тогтоомжид заасан чиг үүргийн дагуу хамтран ажиллахыг хяналт шалгалтын байгууллагаас хүсэх;

43.1.4.энэ хуульд заасан чиг үүргийн хүрээнд хэлэлцүүлэг зохион байгуулах;

43.2.Зөвлөлийн үйл ажиллагааны төсөв болон гишүүдэд олгох мөнгөн урамшлыг төсвөөс санхүүжүүлнэ.

43.3.Зөвлөлийн дүрмийг энэ хууль, бусад хууль тогтоомжид нийцүүлэн хяналт шалгалтын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

44 дүгээр зүйл.Зөвлөлийн дарга, гишүүний бүрэн эрх

44.1.Зөвлөлийн гишүүн нь үйл ажиллагаандаа Монгол Улсын хууль тогтоомжийг чанд мөрдөх ба дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

44.1.1.Зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэж байгаа асуудлаар санал бодлоо чөлөөтэй илэрхийлэх;

44.1.2.энэхүү журамд заасан чиг үүргийг хэрэгжүүлэх талаар санал, санаачилга гаргах;

44.1.3.энэ хуульд заасан журмын дагуу хяналт шалгалтын байгууллага, хүн, хуулийн этгээдтэй хамтран ажиллах;

44.1.4.хүн, хуулийн этгээдээс шаардлагатай мэдээ, мэдээллийг гаргуулан авах;

44.1.5.улс төрийн нам, аливаа эвсэл, хөдөлгөөний шахалт, шаардлагад автахгүй байх, улс төрийн нөлөөллөөс ангид үйл ажиллагаа явуулах;

44.1.6.хүндэтгэн үзэх шалтгаантайгаас бусад тохиолдолд Зөвлөлийн хуралдаанд оролцох.

44.1.7.энэ хуульд заасан чиг үүрэг болон ажил үүргийн хуваарийн дагуу хариуцсан ажил үүргийг хэрэгжүүлж, үр дүнг тайлагнах;

44.1.8.судалгаа, үнэлгээний дүнг нэгтгэн боловсруулж, зөвлөлийн хуралдаанд танилцуулах, холбогдох санал, шийдвэрийг гаргуулах;

44.2.Зөвлөлийн дарга энэ хуулийн 44.1-д зааснаас гадна дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

44.2.1.Зөвлөлийг төлөөлж хяналт шалгалтын байгууллага, болон бусад байгууллага, хүн, хуулийн этгээдтэй харилцах;

44.2.2.Зөвлөлийн хуралдааны товыг зарлан зохион байгуулж, удирдан явуулах;

44.2.3.Зөвлөлийн хуралдаанаас гаргасан санал, мэдээлэл, шийдвэрийг хяналт шалгалтын байгууллагын даргад хүргүүлэх;

44.2.4. Зөвлөлийн ажлыг төлөвлөн зохион байгуулж, удирдах;

44.2.5. Зөвлөлийн даргын эзгүйд түр орлох гишүүнийг томилох.

ДОЛООДУГААР БҮЛЭГ ШАЛГУУЛАГЧ ЭТГЭЭДИЙН НИЙТЛЭГ ЭРХ, ҮҮРЭГ

45 дугаар зүйл.Шалгуулагч этгээдийн эрх, үүрэг

45.1.Шалгуулагч этгээд нь холбогдох хууль тогтоомжийг байгууллагын хэмжээнд хэрэгжүүлэх ажлыг Засгийн газраас тогтоосон нийтлэг журмыг үндэслэн дотоод хяналт шалгалтын журмыг баталж, эрсдэлийн үнэлгээг тогтоож ажиллана.

45.2.Шалгуулагч этгээд нь хяналт шалгалтын ажилд дэмжлэг үзүүлж, улсын байцаагчаас тавьсан шаардлагыг биелүүлж, биелэлтийг тогтоосон хугацаанд нь мэдэгдэх үүрэгтэй.

45.3.Шалгуулагч этгээд нь хяналт шалгалтын үйл ажиллагааны үед дараах эрхтэй:

45.3.1.шалгах болсон үндэслэл шалтгааныг мэдэх, шалгалтын хүрээ, бусад шалгалттай холбоотой асуудлаар тайлбар авах, баримттай танилцах, мэдээллээр хангагдах;

45.3.2.үзлэг, магадлал, туршилт тохируулга, шинжилгээний хариутай танилцах;

45.3.3.зөвлөн туслах үйлчилгээг авах;

45.3.4.шалгалт, түүний дүгнэлт, хяналтын баримт бичгийн талаар гомдол гаргах;

45.3.5.хуульд заасан бусад.

46 дугаар зүйл.Хяналт шалгалтын дүгнэлт, шийдвэрийн баримт бичгийн талаар гомдол гаргах

46.1.Шалгуулагч этгээд хяналт шалгалтын явцад хууль тогтоомж зөрчигдсөн, гаргасан дүгнэлт, шийдвэрийн баримт бичгийг үндэслэлгүй гэж үзвэл улсын байцаагчийн дээд шатны байгууллага, албан тушаалтанд гомдол гаргана.

46.2.Дээд шатны албан тушаалтан гомдлыг хянаад дараах шийдвэрийн аль нэгийг гаргана:

46.2.1.улсын байцаагчийн гаргасан хяналтын баримт бичгийг хэвээр үлдээх;

46.2.2.улсын байцаагчийн гаргасан хяналтын баримт бичигт өөрчлөлт оруулах;

46.2.3.улсын байцаагчийн гаргасан хяналтын баримт бичгийг хэсэгчлэн болон бүхэлд нь хүчингүй болгох.

46.3.Энэ хуулийн 46.2-т заасан шийдвэрийг эс зөвшөөрвөл шүүхэд гомдол гаргаж болно.

НАЙМДУГААР БҮЛЭГ ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН БҮРТГЭЛ, МЭДЭЭЛЛИЙН САН

47 дугаар зүйл.Хяналт шалгалтын бүртгэл, мэдээллийн сан

47.1.Хяналт шалгалтын байгууллага нь хяналт шалгалтын мэдээллийн нэгдмэл байдлыг хангах, зөрчил, алдаа дутагдлын шалтгаан, нөхцөлийг тогтоох, урьдчилан сэргийлэх нэгдсэн бодлого боловсруулах, иргэнд шуурхай үйлчилгээ

үзүүлэх, хэрэглэгчийн үнэлгээг тандах зорилгоор мэдээллийн систем, сан /цаашид “Мэдээллийн сан” гэх/ ашиглана.

47.2.Мэдээллийн сангийн хариуцагч нь Засгийн газрын Хяналтын ерөнхий газар байна.

47.3.Мэдээлэл цуглуулах, боловсруулах, ашиглах, мэдээллийн аюулгүй байдлыг хангах журмыг Засгийн газрын Хяналтын ерөнхий газрын дарга батална.

47.4.Мэдээллийн сангийн мэдээллийг хуулиар хүлээсэн чиг үүрэгтээ хамааралгүй зорилгод ашиглах, хууль, журамд зааснаас бусад тохиолдолд бусдад шилжүүлэхийг хориглоно.

ЕСДҮГЭЭР БҮЛЭГ БУСАД ЗОХИЦУУЛАЛТ

48 дугаар зүйл.Хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага

48.1.Энэ хуулийг зөрчсөн албан тушаалтны үйлдэл, эс үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол Төрийн албаны тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

48.2.Энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

Гарын үсэг

Төсөл

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ... дугаар
сарын ... -ны өдөр

Улаанбаатар
хот

ТӨРИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ТУХАЙ ТУХАЙ ХУУЛЬ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. 2003 оны 1 дүгээр сарын 3-ны өдөр баталсан Төрийн хяналт шалгалтын тухай хуулийг хүчингүй болсонд тооцсугай.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Төр-Иргэний хяналт шалгалтын тухай /Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн шинэчилсэн найруулга/ хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

